

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД  
2025 ОНЫ ХАГАС ЖИЛД ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ  
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Удирдлага, зохион байгуулалт, үндсэн чиг үүргийн  
чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/477 дугаар тушаалаар Цагдаагийн төв байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс өөрчлөгдөн байгуулагдаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах байцаагч 4, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч 4, /үүнээс санхүүгийн 2/ байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үнэлгээ өгөх, эрх бүхий байгууллагад хариуцан тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Дотоод аудит хариуцсан алба хаагчид нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн хэрэгжилтэд нийцлийн, гүйцэтгэлийн, үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод аудит хийх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайн оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аудитын төлөвлөгөө”-г боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн хянуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, биелэлтийг эхний хагас жилээр тооцлоо.

Дотоод аудит хариуцсан ахлах байцаагч нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 3 ажлын хэсэгт орж ажилласан ба Сэлэнгэ, Булган аймгуудад томилолтоор, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас мэргэжлийн зэргийн шалгалт авах салбар комиссын бүрэлдэхүүнд Тэргүүн дэд даргын энэ оны А/18 дугаар тушаалаар 2 алба хаагч Эрүүгийн цагдаагийн алба, Хэрэг бүртгэх алба, Баянгол дүүргийн цагдаагийн газар, Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар, Баян-өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн цагдаагийн газрын хүсэлт гаргасан алба хаагчаас мэргэжлийн зэргийн шалгалт авч, дүнг нэгтгэн алба, газар тус бүрийн удирдлага, бие бүрэлдэхүүнд танилцуулан ажилласан байна.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2025 оны дотоод аудитын төлөвлөгөө”-нд 18 ажил, арга хэмжээ тусгаж хэрэгжүүлснээр биелэлт **90.7** хувьтай байна.

Төлөвлөгөөт **5** дотоод аудитыг хэрэгжүүлж, дотоод аудитад хамрагдсан **65** нэгжид **25** заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж биелэлт, үр дүнг тооцон ажилласан. Үүнд;

- “Цагдаагийн байгууллагаас Төрийн болон төрийн бус байгууллагатай байгуулсан “Санамж бичиг”-ийн хэрэгжилт, үр нөлөө, хэрэгцээ шаардлагын байдал”-д;

- “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа”;

- “Хэрэг бүртгэх албаны мөрдөгч нарын ажлын ачаалал”-д;

- “Тээврийн цагдаагийн албаны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах чиглэлээр гудамж, замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлын ачаалал, хөдөлмөрийн хүнд нөхцлийн байдал”-д;

- “Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтийн байдал”-д сэдэвт **5** дотоод аудитыг хэрэгжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус **8** дотоод аудитыг хэрэгжүүлж, дотоод аудитад хамрагдсан **8** нэгжийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарагдах давхардсан тоогоор **140** нэгжид **46** заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж биелэлт, үр дүнг тооцож ажилласан. Үүнд:

-“Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан ажлын хэсэг байгуулах тухай тушаалын хэрэгжилт, давхардлын байдал”-д хийх төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг **100** буюу “**Бүрэн хэрэгжсэн**” гэж дүгнэсэн.

- Цагдаагийн ерөнхий газрын “Төв байрны алба хаагчдын 2024 онд биеэр эдлээгүй ээлжийн амралтын мөнгөн урамшил олгосон байдал”-д хийх төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг **66.6** буюу “**Хэрэгжих шатандаа** ” гэж дүгнэсэн.

- Цагдаагийн байгууллагын “102 Police” аппликейшний ашиглалт хэрэгжилтийн байдал”-д хийх төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг **80.0** буюу “**Хэрэгжсэн**” гэж дүгнэсэн.

- “Иргэд, алба хаагчдаас авч байгаа сэтгэл зүйн сорил, ярилцлага, арга, аргачлалын байдал”-д хийх төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, аудитын зөвлөмжийг 33 нэгжид хүргүүлсэн.

*Зөвлөмжийн биелэлтийг 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэнэ.*

- “Хар тамхитай тэмцэх газрын алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа”-нд хийх төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж аудитын 9 заалт бүхий зөвлөмжийг 5 нэгжид хүргүүлсэн.

*Зөвлөмжийн биелэлтийг 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор дүгнэнэ.*

- “Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн албан даалгавар, заавар, зөвлөмжийн бүртгэл, чиглэл, агуулга, биелэлт, үр дүнгийн байдал”-д төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг **82.0** буюу “**Хэрэгжсэн**” гэж дүгнэсэн.

- Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны “Хамгаалалт зохицуулалтын газрын Дипломат байгууллага, банкны хамгаалалтын хэлтсийн үүрэг гүйцэтгэл, шөнийн цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад хоолны мөнгө олгогдохгүй байгаа байдал”-д дотоод аудит хийж, 4 заалт бүхий зөвлөмжийг 4 нэгжид хүргүүлсэн.

*Зөвлөмжийн биелэлтийг 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дүгнэнэ.*

- Булган аймгийн цагдаагийн газрын “санхүүгийн үйл ажиллагаа” сэдвээр зэрэг нийт **8 төлөвлөгөөт бус** дотоод аудитыг хэрэгжүүлсэн байна.

### **Дүгнэлт**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2025 оны хагас жилийн дотоод аудитын төлөвлөгөөний биелэлт **90.7** хувьтай хэрэгжсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу **8** төлөвлөгөөт бус дотоод аудитын хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

Дотоод аудитын мөрөөр өгсөн 13 зөвлөмжөөс хугацаа болж дүгнэсэн 8 зөвлөмжийн 42 заалтын биелэлтийг тооцоход 100 хувьтай байна.

Дотоод аудит хариуцсан ахлах байцаагч нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 5 ажлын хэсэгт орж, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Ховд, Говь-алтай аймгуудад томилолтоор ажилласан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад дотоод аудитын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа батлагдсан орон тооны ажлын ачаалалд нийцүүлэн төлөвлөж байгаа боловч, эрэлтэд тулгуурлан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд тулгамдсан болон шийдвэрлэх шаардлагатай асуудлаас шалтгаалан удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийх шаардлага ихээр гарч байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

